

Төрийн албаны зөвлөлийн
2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн
408 дугаар тогтоолын 24 дүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☒ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан
огноо:

Байгууллагын нэр:

Сангийн яам

Албан тушаалын нэр:

Хяналт-шинжилгээ, үнэлгээний
мэргэжилтэн

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын
газрын Дотоод аудит, хяналт-шинжилгээ,
үнэлгээний хэлтэс

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Дэс түшмэл, ТЗ-7

Ажлын байрны албан ёсны байршил:

Монгол Улсын Сангийн яам, Чингэлтэй дүүрэг,
Засгийн газар II байр Д корпус, С.Данзаны
гудамж Улаанбаатар 15160

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Санхүү, төсвийн хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, гэрээний хэрэгжилтийн явц болон сайдын эрхлэх ажлын хүрээний агентлаг, яамны дотоод бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, хэрэглэгчийг зөвлөгөө, мэдээллээр хангах чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1.Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Сангийн яамны үйл ажиллагааны тайлан, Сангийн сайдтай аймаг, нийслэлийн Засаг дарга нарын байгуулсан гэрээний үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.

2.Яамны харьяа агентлаг, дотоод бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, Сангийн сайдын хариуцах гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.

3.Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг яамны удирдлагад танилцуулан, тайланг дээд шатны байгууллагад хүргүүлэх.

4.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын болон нэгжийн дотоод ажилд оролцох, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	Хяналт-шинжилгээ, үнэлгээний журмуудад нийцсэн байна.	Г
	2.Сангийн яамны үйл ажиллагааны тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.		Г
	3.Сангийн сайдтай аймаг, нийслэлийн Засаг дарга нарын байгуулсан гэрээний үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.		Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	Хяналт-шинжилгээ, үнэлгээний журмуудад нийцсэн байна.	Г
	2.Яамны дотоод бүтцийн нэгжүүдийн сар бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.		Г
	3.Сангийн сайдын хариуцах гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.		Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг яамны удирдлагад танилцуулан, үнэлгээний тайланг дээд шатны байгууллагад хүргүүлэх.	Хяналт-шинжилгээ, үнэлгээний журмын дагуу ажилласан байна.	Г
	2.Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр яамны албан хаагчдад мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах.		Г



3 дугаар зорилтын хүрээнд	1.Удирдлагаас хуулийн хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх.	Шуурхай хэрэгжүүлж, эргэн мэдээлсэн байна.	Г
	2.Хариуцсан ажлын чиглэлээр холбогдох дүрэм, журам боловсруулах, мөрдүүлэх.	Хууль, эрх зүй тогтоол, шийдвэрийн дагуу гүйцэтгэсэн байна.	Г
	3.Үйлчлүүлэгчээс ирсэн албан бичиг, санал, өргөдөл, гомдолд хуулийн хугацаанд хариу өгөх.	Өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэсэн байна.	Г
	4.Байгууллагын дотоод журам, ёс зүйн дүрмийг баримталж, байгууллагын соёл, мэндлэх, хүндлэх ёсыг эрхэмлэх.	Ёс зүйн хэм хэмжээг баримталсан байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.		
Мэргэжил	санхүү /041201/, эдийн засаг /031101/		
Мэргэшил	- төрийн албанд мэргэшүүлэх богино, дунд хугацааны сургалтад хамрагдаж, төгссөн байх. - хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдсан бол давуу тал болно.		
Туршлага	Төрийн албанд 4 жил, үүнээс яамны ахлах зохион байгуулагч, зохион байгуулагч тэдгээртэй адилтгах албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх.		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- албан хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх, нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй байх; - тоон мэдээлэлтэй ажиллах, нэгтгэн дүгнэх, статистикийн арга хэрэгслийг ашиглах чадвартай байх; - бусад.	
	Асуудал шийдвэрлэх	- төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг сахих, цаг баримтлах, харилцааны ур чадвартай байх; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх; - шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх; - өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх; - бүтээлч, санаачилгатай ажиллах; - хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; - бусад.	
	Багаар ажиллах	- өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, зохицож ажиллах; - үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - нээлттэй, шударга, бусадтай хамтарч ажиллах чадвартай байх; - бусад.	



	Бусад	- чиг үүргийн дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай байх; - төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулга зүйн чадвартай байх.
--	-------	---

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект

- Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хэлтэс, орон нутгийн харьяа газар, хэлтэс.
- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрүүдийн ажилтан.
- Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

Байгууллагын нэр:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН
УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

..... Б.ДОРЖСЭМБЭД

Шийдвэрийн огноо: 19 12 27

Дугаар: 408

20... оны ... сарын ... -ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

САНГИЙН ЯАМ

Шийдвэрийн огноо: 2019.12.30

Дугаар: 6149

(тамга/тэмдэг)

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.НАРАНЦОГТ

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

